

**2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 09 дүгээр сарын 15-ны “Баасан” гараг, 18-ны “Даваа” гарагийн 12:00 цагаас өмнө e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. **Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.**

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл болон бусад асуудлуудыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан төлөвлөгөөнд тусгуулахаар хүргүүлсэн саналуудаа төлөвлөгдсөн эсэхийг тодруулах.	ЗДТГ, ААНБ-ууд
2	Дүүргийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлж, шаардлагатай бүх нөөцийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах.	ТХҮХ, инженер хангамжийн байгууллагууд, ААНБ
3	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үдийн хоол хөтөлбөрийн хүрээнд эрүүл ахуй, чанар стандартын шаардлагад нийцсэн баталгаат хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах, хүнсний аюулгүй байдалд хяналт шалтгалт зохион байгуулж 10 дугаар сардаа багтаан дүнг танилцуулах.	Боловсролын хэлтэс, ТХҮХ, Эрүүл ахуйн улсын байцаагч
4	Дүүргийн хэмжээнд байгаа хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг нийгэмшүүлэх, хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд рүү хандсан зөвлөмж, сургалтуудыг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулж ажиллах.	ГБХЗХХ, ХХҮХ, Боловсролын хэлтэс, Цагдаагийн хэлтэс
5	Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн осол гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлгөөнд соёлтой оролцуулах чиглэлээр иргэд, олон нийтэд болон нутгийн захиргааны байгууллагуудад уриалж, зөвлөмж чиглэлийг өгч ажиллах.	Цагдаагийн хэлтэс, ААНБ-ууд
6	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн болон гэр хорооллын дундах туслах замын эвдрэл гэмтэл, авто замын тэмдэг, тэмдэглэгээг засварлах ажлуудаа эрчимжүүлж, дуусгах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
7	Хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийн хяналтыг нэмэгдүүлэх, стандарт, технологийн норм нормативыг бүх шатанд мөрдлөг болгох, хяналтын инженерүүдийг газар дээр нь тогтмол ажиллуулж, хяналт тавьж ажиллах.	ХААА, Холбогдох ажлын хэсэг, албан тушаалтнууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
8	Татварын орлого бүрдүүлэлтийн талаарх мэдээллүүдийг нэгтгэн танилцуулах (улс, нийслэл, дүүргийн төсөв ямар ямар орлогоос бүрддэг талаар танилцуулах)	Татварын хэлтэс
9	Нохой, муур устгах ажлыг яаралтай зохион байгуулах	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
10	Боловсролын ерөнхий хуулийн талаарх товч мэдээллийг бэлтгэн танилцуулах (10 минутаас илүүгүй)	Боловсролын хэлтэс
11	ЗДТГ-т бүртгэлтэй худгуудын ашиглалт, хамгаалалтын талаарх мэдээллийг танилцуулах	ЗДТГ
12	Дүүргийн харьяат биш ажилтан, албан хаагчдыг шилжүүлж ирэх ажлыг энэ 7 хоногт багтаан зохион байгуулах.	ААНБ-ууд
13	Шүдний өвчлөлийг бууруулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлт, эмэгтэйчүүдийн эмчтэй болох талаарх ажлуудын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарах.	ЗДО Б.Болормаа НХХ, ЭМТ
14	Явуулын нэг цонхны үйлчилгээний хөтөлбөр гарган, товыг тогтоох	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, ТЗУХ

15	УБЗАА-нд тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл ирэхтэй холбогдуулан машин хүссэн албан хүсэлтээ дахин хэдийд явуулах талаар тодруулан ажиллах.	ЗДО Б.Болормаа, ТХҮХ
16	1, 2 дугаар хороодын айл өрхүүдээс өрхийн үйлдэрлэл эрхлэхийг хүссэн иргэдийн мэдээллийг цуглуулах хүрээнд 2023.10.01-ний дотор судалгаа хийх (ямар чиглэлийн ажил, үйлдвэрлэл эрхлэх чадамжтай, чиг хандлагыг тодорхойлох)	ХХҮХ, ЖДҮҮДТ, Хороод
17	Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж төсөл хэрэгжүүлэх.	ААНБ-ууд
18	Өөрсдийн ажил үйлчилгээг олон нийтэд хүргэхэд анхаарч, шинэлэг арга хэлбэрийг сонгон албан хаагчид ажлын хариуцлагаа нэмэгдүүлэх.	ААНБ-ууд
19	ААНБ-уудад албан бус уулзалтыг зохион байгуулж, харилцан санал солилцох хүрээнд холбогдох ажлын төлөвлөгөө, хуваарийг гарган танилцуулах.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, ГБХЗХХ
20	Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах 2023 оны батлагдсан хуваарийн дагуу засвар үйлчилгээтэй байсан байгууллагуудад нөхөж зохион байгуулах талаар хуваарийг танилцуулан, хэрэгжүүлэх	ТЗУХ

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР